

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/45/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.govisumber@audit.gov.mn">www.govisumber@audit.gov.mn</a></p> <p>Чойр хот 2022 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543156 Цахим хаяг: <a href="mailto:sarantuyab@audit.gov.mn">sarantuyab@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Г.Наранбаяр Утас: 70543179 Цахим хаяг: <a href="mailto:naranbayarg@audit.gov.mn">naranbayarg@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор Ц.Батсайхан Утас: 70543179 Цахим хаяг: <a href="mailto:batsaikhants@audit.gov.mn">batsaikhants@audit.gov.mn</a></p> <p>Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс баланс аудит” ХХК Захирал: Ш.Ичинхорлоо Утас: 77270808 Цахим хаяг: <a href="mailto:nitsbalance@gmail.com">nitsbalance@gmail.com</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
3.6.1 Төсвийн төлөвлөлт.....	12
3.6.2 Төсвийн гүйцэтгэл .....	13
3.6.3 Нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.9.2 Татварын ерөнхий хуулийн хэрэгжилт .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
4.1 Залруулсан алдаа байхгүй.....	14
4.2 Төлбөрийн акт.....	14
4.3 Албан шаардлага .....	15
4.4 Зөвлөмж .....	15

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
БШУЯ	Боловсрол Шинжлэх Ухааны Яам
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>106,491,637.74</b>	<b>106,678,792.74</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>16,436,210.00</b>	<b>3,506,210.00</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>16,436,210.00</b>	<b>3,506,210.00</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>16,436,210.00</b>	<b>3,506,210.00</b>
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	16,436,210.00	3,506,210.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>90,055,427.74</b>	<b>103,172,582.74</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>1,256,500.00</b>	<b>1,187,500.00</b>
35130	Эм боох материал	1,256,500.00	1,187,500.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	0.00	3,430,620.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>88,798,927.74</b>	<b>98,554,462.74</b>
35410	Бичиг хэргийн материал	344,900.00	1,278,900.00
35420	Аж ахуйн материал	71,014,237.74	91,358,237.74
35440	Түлш, шатах тослох материал	585,560.00	921,940.00
35450	Барилгын засварын материал	15,904,030.00	792,800.00
35460	Хүнсний материал	0.00	3,605,585.00
35470	Бусад хангамжийн материал	950,200.00	597,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>883,509,289.08</b>	<b>862,321,713.79</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>883,509,289.08</b>	<b>862,321,713.79</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>802,574,289.08</b>	<b>781,461,713.79</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,357,734,274.65	1,397,971,220.65
39202	Хуримтлагдсан элэгдэл	-784,346,581.76	-836,787,525.32
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	100,505,946.60	141,164,946.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-9,683,099.68	-44,733,805.88
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	120,011,446.22	129,700,323.22
39208	Хуримтлагдсан элэгдэл	-25,775,457.47	-52,654,657.62
39217	Ном	44,127,760.52	46,801,212.14
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>80,935,000.00</b>	<b>80,860,000.00</b>
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-25,000.00	-100,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	80,660,000.00	80,660,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>990,000,926.82</b>	<b>969,000,506.53</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>14,790.00</b>	<b>0.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>14,790.00</b>	<b>0.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>14,790.00</b>	<b>0.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	14,790.00	0.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>989,986,136.82</b>	<b>969,000,506.53</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>989,986,136.82</b>	<b>969,000,506.53</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	440,894,278.52	440,894,278.52
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-170,405,210.57</b>	<b>-191,390,840.86</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-320,255,050.19	-170,405,210.57
51220	Тайлант үеийн үр дүн	149,849,839.62	-20,985,630.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	719,497,068.87	719,497,068.87

6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>990,000,926.82</b>	<b>969,000,506.53</b>
---	--	-----------------------	-----------------------

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,329,526,492.51</b>	<b>1,244,142,947.62</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>217,195,892.51</b>	<b>87,110,147.62</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>217,195,892.51</b>	<b>87,110,147.62</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>18,426,000.00</b>	<b>3,500,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,426,000.00	3,500,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	163,816,078.27	69,366,147.62
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	34,953,814.24	14,244,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,112,330,600.00</b>	<b>1,157,032,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>975,772,400.00</b>	<b>1,016,713,400.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	975,772,400.00	1,016,713,400.00
131009	Хаагдсан данс	0.00	0.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>3,659,300.00</b>	<b>8,420,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	8,420,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,659,300.00	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>132,898,900.00</b>	<b>131,899,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	132,898,900.00	131,899,400.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,179,676,652.89</b>	<b>1,265,128,577.91</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,179,676,652.89</b>	<b>1,265,128,577.91</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,123,839,610.33</b>	<b>1,215,739,692.91</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>797,855,614.30</b>	<b>816,396,327.00</b>
210101	Үндсэн цалин	797,855,614.30	816,396,327.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>96,601,268.00</b>	<b>106,265,186.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	66,751,566.00	74,940,339.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,852,800.00	8,259,191.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,258,721.00	6,533,431.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,429,980.00	1,504,073.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,308,201.00	15,028,152.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>120,861,665.14</b>	<b>121,698,837.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,883,345.14	7,112,172.00
210302	Түлш, халаалт	107,365,280.00	109,802,385.00
210303	Цэвэр, бохир ус	6,613,040.00	4,784,280.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>15,541,669.00</b>	<b>5,813,720.00</b>
210401	Бичиг хэрэг	5,707,170.00	2,333,700.00
210402	Тээвэр, шатахуун	2,190,040.00	1,527,420.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	539,979.00	233,900.00

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 3-р сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210404	Ном, хэвлэл	3,609,300.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,375,180.00	1,538,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>8,736,327.00</b>	<b>5,872,970.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,634,300.00	1,595,000.00
210502	Хоол, хүнс	6,102,027.00	3,869,170.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	408,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,327,520.00</b>	<b>23,320,630.00</b>
210604	Урсгал засвар	9,327,520.00	23,320,630.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,392,600.00</b>	<b>0.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,392,600.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,600,000.00</b>	<b>2,240,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	20,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,440,000.00	2,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	160,000.00	220,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>70,922,946.89</b>	<b>134,132,022.91</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,989,790.00	16,430,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,462,000.00	3,532,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67,471,156.89	114,169,722.91
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>55,837,042.56</b>	<b>49,388,885.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,358,700.00</b>	<b>47,006,720.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,458,700.00	37,986,720.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,900,000.00	9,020,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>734.86</b>	<b>2,363,563.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	734.86	2,363,563.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>30,477,607.70</b>	<b>18,602.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,477,607.70	18,602.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>149,849,839.62</b>	<b>-20,985,630.29</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>149,849,839.62</b>	<b>-20,985,630.29</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>440,894,278.52</b>	<b>719,497,068.87</b>	<b>-</b>	<b>840,136,297.20</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	440,894,278.52	719,497,068.87	-	840,136,297.20
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	149,849,839.62	149,849,839.62
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	440,894,278.52	719,497,068.87	-	989,986,136.82
<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>440,894,278.52</b>	<b>719,497,068.87</b>	<b>-</b>	<b>989,986,136.82</b>

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 3-р сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>440,894,278.52</b>	<b>719,497,068.87</b>	<b>-170,405,210.57</b>	<b>989,986,136.82</b>
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-20,985,630.29	-20,985,630.29
<b>2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>440,894,278.52</b>	<b>719,497,068.87</b>	<b>-191,390,840.86</b>	<b>969,000,506.53</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,134,738,250.00</b>	<b>1,163,587,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>18,426,000.00</b>	<b>3,500,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>18,426,000.00</b>	<b>3,500,000.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>18,426,000.00</b>	<b>3,500,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,426,000.00	3,500,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,116,312,250.00</b>	<b>1,160,087,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>975,772,400.00</b>	<b>1,016,713,400.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	975,772,400.00	1,016,713,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>7,640,950.00</b>	<b>11,474,200.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,981,650.00	8,420,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,659,300.00	3,054,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>132,898,900.00</b>	<b>131,899,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	132,898,900.00	131,899,400.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,117,846,590.00</b>	<b>1,152,901,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,117,846,590.00</b>	<b>1,152,901,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,062,009,547.44</b>	<b>1,100,081,495.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>786,939,806.30</b>	<b>838,846,503.00</b>
210101	Үндсэн цалин	582,475,351.96	491,968,912.23
210102	Нэмэгдэл	117,349,527.92	287,052,008.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,906,796.00	1,783,000.00
210104	Урамшуулал	78,208,130.42	58,042,582.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>107,141,100.00</b>	<b>83,829,800.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	77,230,900.00	75,773,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,747,500.00	2,014,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,195,900.00	1,611,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,633,500.00	403,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,333,300.00	4,028,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>120,861,665.14</b>	<b>121,698,837.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,883,345.14	7,112,172.00
210302	Түлш, халаалт	107,365,280.00	109,802,385.00

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 3-р сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	6,613,040.00	4,784,280.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,267,429.00</b>	<b>13,961,400.00</b>
210401	Бичиг хэрэг	670,000.00	1,605,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,775,600.00	1,863,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	539,979.00	646,100.00
210404	Ном, хэвлэл	3,753,850.00	3,054,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	222,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,288,000.00	6,570,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,742,807.00</b>	<b>8,524,155.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	500,000.00	620,000.00
210502	Хоол, хүнс	2,321,707.00	7,474,755.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	921,100.00	429,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,036,500.00</b>	<b>7,847,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	10,000.00
210604	Урсгал засвар	12,036,500.00	7,837,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,392,600.00</b>	<b>0.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,392,600.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,966,800.00</b>	<b>2,820,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,306,800.00	600,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,440,000.00	2,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	220,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>8,660,840.00</b>	<b>22,553,800.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,589,790.00	16,430,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,071,050.00	6,123,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>55,837,042.56</b>	<b>52,819,505.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,358,700.00</b>	<b>50,437,340.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,458,700.00	41,417,340.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,900,000.00	9,020,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>734.86</b>	<b>2,363,563.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	734.86	2,363,563.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>30,477,607.70</b>	<b>18,602.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,477,607.70	18,602.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>16,891,660.00</b>	<b>10,686,000.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>455,450.00</b>	<b>23,616,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>455,450.00</b>	<b>23,616,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>455,450.00</b>	<b>23,616,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	455,450.00	23,616,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-455,450.00</b>	<b>-23,616,000.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>16,436,210.00</b>	<b>-12,930,000.00</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	16,436,210.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16,436,210.00	3,506,210.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,148,612,800.00</b>	<b>1,146,230,635.00</b>	<b>2,382,165.00</b>	<b>99.8</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,148,612,800.00</b>	<b>1,146,230,635.00</b>	<b>2,382,165.00</b>	<b>99.8</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,098,174,300.00</b>	<b>1,095,793,295.00</b>	<b>2,381,005.00</b>	<b>99.8</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>838,857,700.00</b>	<b>838,846,503.00</b>	<b>11,197.00</b>	<b>100.0</b>
210101	Үндсэн цалин	678,815,000.00	491,968,912.23	186,846,087.77	-72.5
210102	Нэмэгдэл	132,752,400.00	287,052,008.77	154,299,608.77	216.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,800,300.00	1,783,000.00	17,300.00	99.0
210104	Урамшуулал	25,490,000.00	58,042,582.00	32,552,582.00	227.7
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>83,829,800.00</b>	<b>83,829,800.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	75,773,800.00	75,773,800.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,014,000.00	2,014,000.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,611,000.00	1,611,000.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	403,000.00	403,000.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,028,000.00	4,028,000.00	0.00	100.0
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>124,062,400.00</b>	<b>121,698,837.00</b>	<b>2,363,563.00</b>	<b>98.1</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,700,000.00	7,112,172.00	587,828.00	92.4
210302	Түлш, халаалт	109,802,400.00	109,802,385.00	15.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	6,560,000.00	4,784,280.00	1,775,720.00	72.9
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,982,200.00</b>	<b>10,982,200.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210401	Бичиг хэрэг	1,605,000.00	1,605,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	1,863,800.00	1,863,800.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	646,100.00	646,100.00	0.00	100.0
210404	Ном, хэвлэл	75,000.00	75,000.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	222,000.00	222,000.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,570,300.00	6,570,300.00	0.00	100.0
2105	<b>Нормативт зардал</b>	<b>8,110,400.00</b>	<b>8,104,155.00</b>	<b>6,245.00</b>	<b>99.9</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	200,000.00	200,000.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	7,481,000.00	7,474,755.00	6,245.00	99.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	429,400.00	429,400.00	0.00	100.0

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 3-р сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>26,837,000.00</b>	<b>26,837,000.00</b>	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,000,000.00	19,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	7,837,000.00	7,837,000.00	0.00	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,820,000.00</b>	<b>2,820,000.00</b>	0.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	600,000.00	600,000.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	220,000.00	0.00	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,674,800.00</b>	<b>2,674,800.00</b>	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,674,800.00	2,674,800.00	0.00	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>50,438,500.00</b>	<b>50,437,340.00</b>	1,160.00	100.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>50,438,500.00</b>	<b>50,437,340.00</b>	1,160.00	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	41,418,500.00	41,417,340.00	1,160.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,020,000.00	9,020,000.00	0.00	100.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,148,612,800.00</b>	<b>1,146,230,635.00</b>	2,382,165.00	99.8
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,016,713,400.00</b>	<b>1,016,694,798.00</b>	18,602.00	100.0
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,016,713,400.00	1,016,694,798.00	18,602.00	100.0
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>131,899,400.00</b>	<b>129,535,837.00</b>	2,363,563.00	98.2
320001	Орон нутгийн төсвөөс	131,899,400.00	129,535,837.00	2,363,563.00	98.2
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>788.00</b>	<b>788.00</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>		
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>54.00</b>	<b>54.00</b>		
620001	Удирдах ажилтан	1.00	1.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	39.00	39.00		
620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00		

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>11,474,200.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>11,474,200.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>11,474,200.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,054,200.00</b>

210404	Ном, хэвлэл	3,054,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	420,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	420,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,000,000.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>11,474,200.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>11,474,200.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,420,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,054,200.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 3 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад НӨАТ-ын төлбөрийн баримтын цахим систем, цалингийн зардал, бараа материалын зардлын ангилалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудит Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Эн Ай Ти Эс баланс аудит” ХХК-ийн аудитор Ч.Ганчулуун гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер И.Туяа, захирал Ш.Ичинхорлоо, дараагийн шатны чанарын хяналтыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Г.Наранбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 3 дугаар сургууль 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 3 дугаар сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Уламжлалт ёс заншил, өв соёлоо дээдэлдэг хүндэлдэг, Зөв монгол хүнийг төлөвшүүлэх” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Үндэсний хэл түүх, өв соёл, заг заншил
- Уламжлал, шинэчлэл

- Нээлттэй ил тод байдал
- Эрх тэгш оролцоо

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д: “Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана”; /2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/
- МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор баталсан “Ковид 19” цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай”;
- МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 267 дугаар тушаалаар баталсан “Цахилгаан, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах тухай”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 3 дугаар сургууль 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн баталсан төсвийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн нийт зардал 478,660.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,786.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 3,350.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 3 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21,000.4 мянган

төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

**Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	16,436.2	3,506.2	(12,930.0)
Авлага	-	-	-
Бараа материал	90,055.4	103,172.5	13,117.1
Бусад эргэлтийн хөрөнгө			-
Үндсэн хөрөнгө	883,509.3	862,321.7	(21,187.6)
Нийт хөрөнгө	990,000.9	969,000.5	(21,000.4)
Богино хугацаат ер төлбөр	14.8		(14.8)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	989,986.1	969,000.5	(20,985.6)
Нийт ер төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	990,000.9	969,000.5	(21,000.4)

Бараа материалын дансны үлдэгдэл 103,172.5 мянган төгрөг болж 13,117.1 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүйгээр аж ахуйн материал орлого авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 21,187.6 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 969,000.5 мянган төгрөг болж 20,985.6 мянган төгрөгөөр буурсан нь бараа материал үндсэн хөрөнгө, дансны өглөгийн өөрчлөлтөөс шалтгаалж байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 85,383.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан дараах орлогууд байна. Үүнд:

- Туслах үйл ажиллагааны орлогоос 14,926.0 мянган төгрөгийн бууралт;
- Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал, үндсэн хөрөнгөний орлогоос 115,159.8 мянган төгрөгийн бууралт;
- Тусгай урсгал шилжүүлгийн санхүүжилтээс 40,941.3 мянган төгрөгийн өсөлт;
- Нэмэлт санхүүжилтийн орлогоос 4,760.7 мянган төгрөгийн өсөлттэй байна.

Нийт зардал өмнөх оноос 85,452.0 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал, норматив зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардлууд байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 1,265,128.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 116,515.2 мянган төгрөгөөр бууруулж 1,148,612.8 мянган төгрөгөөр баталсан байна. Улсын төсвөөс санхүүжилтийг 1,016,713.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 131,899.4 мянган төгрөгөөр баталжээ.

Төсвийг 12 дугаар сард 1,148,612.8 мянган төгрөгөөр баталсан байна. Улсын төсвөөс санхүүжилтийг 1,016,713.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 131,899.4 мянган төгрөгөөр баталжээ

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,148,612.8 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 1,016,713.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 131,899.4 мянган төгрөг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,016,694.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 129,535.8 мянган төгрөг, нийт 1,146,230.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 99.8 хувьтай байгаа нь бараа, ажил үйлчилгээний зардал 2,381.0 мянган төгрөг, урсгал шилжүүлэгийн зардалд 1.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 8,420.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,054.2 мянган төгрөг, нийт 11,474.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, үйлчилгээний зардалд 8,420.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Дэлхийн нийтээр Ковид-19 өвчлөлтэй холбоотойгоор БШУЯ-ны сайдын тушаалын дагуу сургалтын үйл ажиллагааг 3, 9, 10, 11, 12 саруудад буюу 5 сар танхимаар болон цахимаар хосолсон хэлбэрээр явуулсан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 3 дугаар сургуулийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.5 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1,

6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зорицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 3 дугаар сургууль 2021 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас тухай бүр оруулах 2, сар бүрийн оруулах 1, бүтэн жилээр оруулах , нийт 6 мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.9.2 Татварын ерөнхий хуулийн хэрэгжилт**

Тайлант онд нийт 9,808.7 мянган төгрөгийн төлбөрийн баримтыг цахим системд шивүүлээгүй, хянаж, баталгаажуулаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Татварын ерөнхий хуулийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх аудитаар өгсөн 3 төлбөрийн акт, 2 зөвлөмж хэрэгжиж, 4 албан шаардлагаас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах хэрэгжилт хангалтгүй, тайлант онд зөрчил давтагдсан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитын нийт 52,752.9 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс 52,517.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж, 235.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшинээс 49,402.0 мянган төгрөг их хэдий ч санхүүгийн тайланд нөлөөлөлгүй тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

### **4.1 Залруулсан алдаа байхгүй**

### **4.2 Төлбөрийн акт**

#### 1.1 Илрүүлэлт:

Тайлант онд нийт 235.9 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг илүү тооцон олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

#### **4.3 Албан шаардлага**

##### **4.3.1**

#### **4.4 Зөвлөмж**

##### **1. Бараа материалын зардалтай холбоотой**

###### 1.1 Илрүүлэлт:

Бараа материалын тодруулга тайланд 41,417.3 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зөв ангилж тайлагнаагүй нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", санхүүгийн тайлагналын ангилал "ажил гүйлгээ, үйл явдлыг зөв дансанд ангилж бүртгэсэн байх" гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

###### 1.2 Өгсөн зөвлөмж:

Бараа материалын зардлыг зөв ангилж бүртгэж байх.

##### **2. Худалдан авалттай холбоотой**

###### 2.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд хийсэн зарим худалдан авалтаас 9,808.7 мянган төгрөгийн төлбөрийн баримтыг цахим төлбөрийн баримтын системд шивүүлээгүй байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д *"Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй"* гэсэн заалтын дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

###### 2.2 Өгсөн зөвлөмж:

Худалдан авалтын төлбөрийн баримтыг цахим системд тухай бүр шивүүлж, хяналт хэрэгжүүлж байх

##### **3. Цалингийн зардалтай холбоотой**

###### 3.1 Илрүүлэлт:

Тайлант онд ажилтнуудад батлагдаагүй орон тооны ажлыг хавсран гүйцэтгүүлж, 1,291.0 мянган төгрөгийн нэмэгдэл тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д заасан "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

###### 3.2 Өгсөн зөвлөмж:

Цаашид залруулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах.

##### **4. Дотоод хяналттай холбоотой**

###### 4.1 Илрүүлэлт

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас тухай бүр оруулах 2, сар бүрийн оруулах 1, бүтэн жилээр оруулах , нийт 6 мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх гэсэнтэй нийцэхгүй байна. Санхүүгийн тайлагналын Ангилал, иж бүрэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

###### 4.2 Өгсөн зөвлөмж

Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдаа зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мөнгөн хөрөнгийн тайлангийн төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллаас 41,417.3 мянган төгрөгийн хоол хүнсний материал худалдан авч бэлэн бүтээгдэхүүн дансанд орлого авч бүртгэсэн.	1	41,417.3							1	41,417.3
2	Тайлант хугацаанд хийсэн зарим худалдан авалтаас 9,808.7 мянган төгрөгийн төлбөрийн баримтыг цахим төлбөрийн баримтын системд шивүүлээгүй байна	1	9,808.7							1	9,808.7
3	Тайлант онд нийт 239.9 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг илүү тооцон олго-сон. Үүнд, Ц.Цолмонгэрэлд 212.1 мянган төгрөг, Р.Отгонд 23.8 мянган төгрөг.	1	235.9			1	235.9				
4	Дараах ажилт-нуудад батлагдаагүй орон тоонд хавсран гүйцэтгэх нэмэгдэл 1,291.0 мянган төгрөгийг бодож олгосон. Үүнд: С.Дагмидад 317.5 мянган төгрөг, Ж.Сүрэнд 643.8 мянган төгрөг, Г.Нарантуяад 329.7 мянган төгрөг.	1	1,291.0							1	1,291.0
5	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тухай бүр оруулах мэдээлэл 2, сар бүрийн оруулах мэдээлэл 1, улирал бүр оруулах мэдээлэл 1, бүтэн жилээр оруулах мэдээлэл 2-г тус тус хугацаа хоцруулан байршуулсан	1	-							1	
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>5</b>	<b>52,752.9</b>			<b>1</b>	<b>235.9</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>52,517.0</b>